**Олон зөв хариултыг сонгоно уу.**

**1,2,3 зөв бол А**
**1,2,3,4 зөв бол В**
**2,4 зөв бол С**
**Зөвхөн 4 зөв бол Д**
**Бүгд зөв бол Е**

**Хэт авиан шинжилгээгээр ихэр жирэмснийг үнэлэхтэй холбоотой зөв мэдээллийг заана уу.**

1. Жирэмсний эхний 3 сард ихэсжилтийн хэлбэрийг тогтооно
2. “Т” болон “Лямбда” шинж эхний 3 сард илүү тод харагдана
3. Хоёр өөр хүйсийн урагт монохорион хэлбэрийн ихэсжилт тодорхойлогдох ёсгүй
4. Эхний 3 сард ихэсжилтийг тогтоогоогүй, ургийн хүйс ижил бол монохорион ихэр гэж үзнэ

5. Ихэр урагтай жирэмсний зулай ахар сүүлний уртыг 8- 10 долоо хоногтойд хэмжих нь илүү бодитой байна

**2 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Эх доторх ихэр жирэмсний нэг ураг эндэхтэй холбоотой зөв мэдээлэлийг нэрлэнэ үү
1. Нөгөө ураг эндэх эрсдэл 15%
2. Амьд үлдсэн ураг мэдрэлийн хүнд гэмтэлтэй төрөх эрсдэл 25%
3. Дутуу төрөх эрсдэл 60-70%
4. Жирэмсний <24 өмнө нэг ураг эндэхэд амьд үлдсэн урагт мэдрэлийн хүнд гэмтэл тохиолдох нь илүү
5. Амьд үлдсэн ургийг 28 долоо хоногтойд MRI хийж тархины гэмтлийг үнэлнэ.

**3 Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Эхний 6 дахь долоо хоногтойд "Vanishing Twin syndrome" буюу нэг ураг алга болох шинж тохиолддог. Энэ нь ойролцоогоор хэдэн хувьд илрэх вэ?

1. 3-5%
2. 5-10%
3. 10-15%
4. 15-20%
5. 20-25%

**4** **Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Жирэмсний 30 долоо хоногтойгоос өмнөх хугацаанд ургийн өсөлтийн саатлын үед юуг үндэслэн төрөлтийн төлөвлөлтийг боловсруулахыг зөвлөсөн бэ? удирдамжаар

1. КТГ
2. Венийн цоргоны цусны урсгалын Допплер
3. Умайн Артерийн Допплер
4. Хүйн артерийн Допплер
5. Ургийн тархины дунд артерийн Допплер

**5** **Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Жирэмсэн үед B вирусын хепатитын DNA хэдээс дээш бол 28 долоо хоногтойгоос вирусын эсрэг тенофовир эсвэл телбивудин хэрэглэхийг зөвлөсөн бэ?

1. ≥50,000IU/ml
2. ≥100,000IU/ml
3. ≥150,000IU/ml
4. ≥200,000IU/ml
5. ≥250,000IU/ml

**6 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн хэт авиан оношилгоонд суурилсан QUINTERO -ийн ангилалын 2-р үе шатны ангилалд аль хамаарах вэ?
1. Судасны Допплер хэвийн байна
2. Ураг орчмын шингэний ихсэлт ба багасалт
3. Хүлээн авагч урагт гидропс илэрнэ
4. Донор урагт давсаг харагдахгүй
5. Ургийн зүрхний гажиг илрэх нь цөөнгүй

1. 1, 2, 3 дугаар хариултууд зөв
2. 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв
3. 2 ба 4 дугаар хариултууд зөв
4. Зөвхөн 4-р хариулт зөв
5. Бүх хариулт зөв

**7 Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Хүүхдэд сэтгэл зүйн гэмтлээс үүссэн хор нөөг илрүүлэх CRIES асуумжийн аргаар хэдэн онооноос дээш бол гэмтлийн дараах хүнд стресс гэсж үнэлэх вэ?

1. 20
2. 30
3. 35
4. 40
5. >45

**8** **Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Бэлэг бойжлын үе гэдэгт хэдэн насыг хамааруулах вэ?

1. 8-16 нас
2. 8-18 нас
3. 8-19нас
4. 10-16нас
5. 10-19 нас

**9** **Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Ураг хэт авиан шинжилгээгээр Биофизик үзүүлэлт <2-оос бага оноотой үед урагт хүчилшилт үүсэх магадлал хэдэн хувь вэ?

1. 20%
2. 40%
3. 60%
4. 80%
5. 100%

**10 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Хожуу илрэх өсөлтийн саатлын эмнэлзүйд хамааралтайг нэрлэ

1. Нийт өсөлтийн саатлын 30% орчмыг эзэлнэ.
2. Ургийн биофизик үзүүлэлт хэвийн бус байна.
3. Жирэмсний холбоотой А/Д ихсэлттийн шалтгаантай шууд хамааралтай
4. Ураг хэт жижиг биш
5. Пренатал эндэгдэл эрт үеийн өсөлттэй харьцуулахад өндөр

**11 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Төрөлхийн тэмбүүгийн оношилгооны “гол шалгуур”-ыг нэрлэнэ үү.

1. Ринит
2. Ам уруулын цуурал
3. Тунгалаг булчирхайн томрол
4. Остеохондритит
5. Өргөн суурьтай кондилом

**12** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

ХХВ-ийн эсэрг вакцинтай холбоотой зөв мэдээлэлийг нэрлэнэ үү

1. Дөрвөн цэнт вакцин бэлгийн үү үүсэх эрсдэлийг бууруулна
2. ХХВ-ийн 16 ба 18 хэв шинжиийн өмөнгөөс >90% хамгаална
3. Вакцинд 9-13 насны охидыг хамруулна
4. Вакцин нь сулрууласан амьд вакцин тул эх, урагт сөрөг нөлөө үзүүлнэ
5. Дараагийн 2 дахь тунг 3 сарын дараа хийнэ

## 13 Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно)

MRI шинжилгээгээр умайн хүзүүний хортой хавдрыг оношлох ба тунгалагын булчирхайн үсэрхийллийг илүү сайн оношилно.

1. Зөв, Зөв, Зөв
2. Зөв, Зөв, Буруу
3. Зөв, Буруу, Буруу
4. Буруу, Зөв, Буруу
5. Буруу, Буруу, Буруу

**14 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Жирэмсний тээлтийн эхний 3 сарын хэт авиан оношлогоонд хамааралтай зөв мэдээллийн нэрлэнэ үү.

1. Ураг хэвийн байрлалтай үед цээж эрүүний хооронд ураг орчмын шингэн харагдах ёсгүй.
2. УЗЦ 37 хоногтойгоос тодорхойлогдоно
3. Ургийн зулай ахар сүүл нь бага байх нь ураг өсөлтгүй болохын урьдал шинж
4. Тээлтийн 10 дахь долоо хоногоос тархины судаслаг багц харагдана
5. Жирэмсний тээлтийн хугацааг 7-8 долоо хоногтойд үнэн зөв тогтооно

**15** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

Жирэмсний 11-13+6 долоо хоногт ургийн бүтцийн алийг нь тодорхойлох шаардлагатай вэ?

1. Хүзүүний арын тунгалаг зай
2. Сарвуу тавхайн хэвийн байрлал
3. Давсаг
4. Уруул
5. Хүйн судас

**16** **Зөв нэг хариултыг сонгоно уу.**

Эмэгтэй жирэмслэх хүсэлтэй бол умайн хүзүүний хортой хавдрын аль шат хүртэл умайг авах төгс мэс засал хийхгүй байж болох вэ?

1. IA1
2. IA2
3. IB
4. II A
5. II B

**17 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үйл ажиллаганы насжилтын STRAW10+ шатлалаар цэвэршихэд шилжих хожуу шатанд хамааралтайг нэрлэнэ үү

1. Гурван жил хүртэл үргэлжилнэ
2. БЮМ 60 ба түүнээс дээш хоногоор саатна
3. ФСД >25 IU/l байна
4. Антрал фолликулын тоо маш цөөрнө
5. Ингибин B хэмжээ нэмэгдэнэ

**18** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

Цэвэршилтийн үед жирэмслэхээс сэргийлэх талаарх зөв мэдээллийг нэрлэнэ үү
1. Бичил болон бага тунтай этинилэстрадиол агуулсан бэлдмэл тохиромжтой
2. Дааврын хавсарсан эм нь цэвэршилтийн шинж тэмдгийг бууруулах ач холбогдолтой
3. ДХЭ-ийг хэрэглэхдээ тромбоз үүсэх эрсдэлийг үнэлнэ
4. Хуанлын аргыг зөвлөхгүй
5. 50 ба түүнээс дээш настай эмэгтэйчүүдэд сүүлийн биеийн юм ирснээс хойш жирэмслэхээс сэргийлэх шаардлагагүй

**19** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

Дараах эмгэгүүдээс аль нь ясны сийрэгжилт үүсгэх өндөр эрсдэлтэй вэ?

1. Кушингийн хам шинж
2. Гипертиреодизм
3. Гиперпаратиреодизм
4. Хэрлэгийн шалтгаант үений үрэвсэл
5. Элэг ба бөөрний архаг үрэвсэл

**20** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

Цэвэршилтийн үед даавар нөхөх эмчилгээнд хэрэглэгддэг бэлдмэлүүдийг нэрлэнэ үү

1. Дан эстроген
2. Эстроген ба гестаген
3. Эстрогены авуурт сонгомол үйлчлэх модулятор
4. Гонадомиметик
5. Тестостерон

**21** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

Цэвэршилтийн үед дараах дааврын бус эмүүдийн алийг нь хэрэглэх вэ?

1. Клонидин
2. Тиболон
3. Габапентин
4. Пароксетин
5. Флюоксетин

**22** **Олон зөв хариултыг сонгоно уу.**

Дараахаас өндгөвчийн хортой хавадр үүсгэх эрсдэлтэйг нэрлэнэ үү

1. Өндгөвч уйланхайжих
2. Удамшил
3. BRCA 1 ба BRCA 2-ын мутац
4. Оройтож цэвэрших
5. Линчийн хам шинж

**23 Олон зөв хариултыг сонгоно уу.**

Жирэмсний лютеома -той холбоотой зөв мэдээлэйиг нэрлэнэ үү
1. Жирэмсэн үед дааврын идэвхижилтэй холбоотой үүснэ
2. Өндгөвчийн эд шар биежсэн тулгуур эдээр солигдоно
3. Дахих эрсдэл өндөртэй
4. Эхэд эрших шинж илэрнэ
5. Эрэгтэй ураг төмсөгний хавдар үүсэх эрсдэлтэй

24. Зөв нэг хариултыг сонгоно уу.

Өндгөвчийн хавдрын үсэрхийлэлийн индекс (RMI) хэдээс дээш оноотой бол үсэрхийлэх эрсдэлтэй гэж үзэх вэ?

1. RMI > 50 оноо
2. RMI > 100 оноо
3. RMI > 150 оноо
4. RMI > 200 оноо
5. RMI > 250 оноо

**25** **Зөв нэг хариултыг сонгоно уу.**

**Уялдуулан сонгох сорил.** Доорх биомаркерууд нь ямар хавдруудыг илрүүлэх боломжтойг тохируулан сонгоно уу

1. CEA (cancer embryonal antigen) /B/
2. AFP (Alpha-Fetoprotein) /C/
3. ЛДГ (лактодегидрогеназа) /A/
4. Ингибин A ба B /D/
5. CA-125 (cancer antigen 125) /E/

A. Дисгерминома
B. Өндгөвчийн муцинозын хортой хавдар
C. Шар уургийн хүүдийн хавдар
D. Өндгөвчийн бэлгийн татлагын хавдар
E. Өндгөвчийн хучуурын хавдар

1. 1C 2B 3A 4D 5E
2. 1B 2C 3D 4A 5B
3. 1C 2A 3B 4D 5E
4. 1B 2C 3A 4D 5E
5. 1A 2E 3C 4D 5B

## 26 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Жирэмслэхээс өмнө фолийн хүчил ууснаар урагт мэдрэлийн гуурсны гаж хөгжил үүсэх эрсдэлийг хэдэн хувь бууруулах вэ?

1. 11%
2. 26%
3. 50%
4. 72%
5. 90%

## 27 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Дэлхийд хамгийн түгээмэл тохиолдох нэг генийн эмгэгт аль нь хамаарах вэ?

1. Гемоглобинопати
2. Гликоген нөөцлөгдөх өвчин
3. Фенилкетонури мутаци
4. Уйланхайт фиброз
5. Дюшены булчингийн дистрофи

## 28 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Жирэмсний аль хугацаанаас агаарын тээврээр зорчихыг зөвлөдөггүй вэ?

1. 26 долоо хоног
2. 28 долоо хоног
3. 30 долоо хоног
4. 32 долоо хоног
5. 36 долоо хоног

## 29 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Жирэмсэн үед Кортикотропийн сэдээгч дааврын анхдагч эх үүсвэр аль нь болохыг нэрлэнэ үү?

1. Ихэс
2. Ургийн бөөрний дээд булчирхай
3. Ургийн харааны товгор
4. Эхийн харааны товгор Хорион бүрхүүл

Оноо : 1

**30** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Дауны хам шинжийг илрүүлэхэд Жирэмсний 19-24 долоо хоногтойд ургийн арьсны зузааны босго хэмжээ зурагт харуулсан цагаан тэмдэгтээр хэд бол эерэг гэж үзэх вэ?




1. ≥6 мм
2. ≥7 мм
3. ≥8 мм
4. ≥9 мм
5. ≥10 мм

**31** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Mirror буюу толин тусгал хам шинжид дараахаас аль нь хамаарах вэ?

1. Эхийн хаван
2. Артерийн даралт ихсэлт
3. Шээсээр уураг алдах
4. Ургийн гидропс
5. Элэгний трансаминаз ихсэх

**32** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Ургийн тахиаритми гэдэг нь ургийн зүрхний цохилт 1 минутанд 180-200 удаа болохыг хэлнэ. Ямар шалтгаанаас үүсэх вэ?

1. Бамбайн дутагдаl
2. Ургийн халдвар
3. Манас таталтын урьдлын хүнд хэлбэр
4. Ургийн цус багадалт
5. 28 долоо хоног хүртэл урагт илэрч болно

## 33 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

Ургийн уушгины хөгжлийг үнэлэх аргуудыг нэрлэнэ үү
1. Ургийн шингэнд лецитин-сфингомиелины харьцааг
2. Ламел биетийг тоолох
3. Фосфатидилглицерин (PG)
4. Хэт авиан оношилгоо
5. Фибронектин

## 34 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Дутуу төрөлтийн үед умайн булчингийн агшилтыг зогсоох зорилгоор хэрэглэх Нифидепины цохилтын тунг нэрлэнэ үү?

1. 10 мг-аар 20 хормын зайтай 3 удаа
2. 20 мг-аар 20 хормын зайтай 3 удаа
3. 30 мг-аар 20 хормын затай 3 удаа
4. 30 мг-аар 1 удаа
5. 10 мг-аар 10 мин зайтай 3 удаа

**35** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Ураг орчмын шингэн цагаас өмнө гарсан хүлээх төлөвлөгөөтэй бол ямар арга хэмжээ авах вэ?

1. Үтрээний үзлэгийг 12 цагийн зайтай хийнэ
2. Биеийн халууныг 4 цагийн зайтай үзнэ
3. Цусанд цагаан эсийг 12 цаг тутамд үзнэ
4. Цусанд С уургийг өдөр бүр үзнэ
5. 37 долоо хоног хүрээгүй бол токолитик хэрэглэнэ

**36** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Донорын цусанд ямар халдварыг заавал илрүүлэх вэ?

1. ХДХВ
2. Тэмбүү
3. В гепатит
4. С гепатит
5. Цитомегаловирус

**37 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Цус буруу сэлбэснээс үүдэлтэй анафилаксийн дайрлагын үед хийх эмчилгээнээс хамааралтайг нэрлэнэ үү

1. Адреналин
2. Прометазин
3. Гидрокортизон
4. Амминофиллин
5. Аналгин

**38. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Лидокайныг хэсгийн мэдээ алдууладлтанд 40 мл-ээс их хэмжээтэй хэрэглэхээр бол адреналиныг ямар тунгаар нэмж өгөх вэ?

1. 2 мкг/кг
2. 5 мкг/кг
3. 6 мкг/кг
4. 8 мкг/кг
5. 10 мкг/кг

39. **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)** Цулцан хурааг цэвэрүүлсэн эмэгтэйд ямар хугацаанд ХГД -ыг хэвийн байдалд хүрэхгүй бол хориокарциномын удирдамжийн дагуу хавдар судлалын төвд шилжүүлэх вэ?

1. 4 долоо хоног
2. 6 долоо хоног
3. 8 долоо хоног
4. 10 долоо хоног
5. 12 долоо хоног

**40. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

BRCA 1 нь өндгөвчний өмөн үүсэх эрсдэлийг хэдэн хувь нэмэгдүүлэх вэ?

1. 15%
2. 20%
3. 30%
4. 40%
5. 50%

**41. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Ургийн биофизик үзүүлэлтээр ургийн амьсгалын хөдөлгөөн 30 секудэд хэдэн удаа илэрвэл 2 оноо өгөх вэ?

1. 0
2. 1
3. 2
4. 3
5. 4

**42. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Төрсний дараа дунд чөмөгний мэдрэл дарагдлын шинжтэй хамааралтай зөв мэдээллийг нэрлэнэ үү?

1. Удаан хугацаагаар өвдөг нугалаатай байх
2. Мак Робертсийн байрлалд удаан байлгах
3. Дүлэлтийн үед шилбэний нарийн ясанд даралт учирснаас
4. Гуяны урд дотор талын мэдрэхүй алдагдах шинж илэрнэ
5. Хүндээр бие засах мэдрэмж өөрчлөгдөх

**43. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Макроцитарный цус багадалтанд аль нь хамаарах вэ?

1. Остеомиелит г.м халдвар
2. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
3. Хар тугалганы хордлого
4. Эмийн хамааралтай
5. Хадуур эсийн цус багадалт

**44. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Ургийн шингэний бүрхүүлийг хагалсны дараа хэдэн цагийн дараа төрөх үйл ажиллагаа жигдрэхгүй бол В стрептококкийн халдвараас сэргийлж антибиотикт эмчилгээг эхлэх вэ?

1. Ургийн шингэнийг цоолсны дараа шууд
2. 4 цагийн дараа
3. 6 цагийн дараа
4. 8 цагийн дараа
5. 12 цагийн дараа

**45. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

FIGO 2018 Мизопростолын удирдамжаар мизопростолыг шингэлж уулгахтай холбоотой зөв мэдээлэлийг нэрлэнэ үү

1. 200 мкг тунг 25 мл бүлээн усанд найруулна
2. Бэлтгэсэн уусмалыг 2 цаг тутам уулгана

3. Амин үзүүлэлтүүдийг 4 цаг туамд хянаж төрөлтийн түүхэнд тэмдэглэнэ
4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн бол тунг бууруулаад төрөх хүртэл уулгаж болно
5. Хэрэв 4 тунгийн дараа төрөх йл ажиллагаа эхлэхүй бол мизопростолыг зогсооно

## 46 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Эмэгтэй 14 долоо хоног БЮ ирээгүй, жирэмсний тест эерэг гарсан. Хэт авиан шинжилгээнд түүний ерөндөг нь умайн хүзүүний сувагт харагдана. Дараахийн аль нь зөв арга хэмжээ болох вэ

1. Ерөндөгийг авна
2. Ерөндөгийг авна, мөн хэвлийн хөндийг дурангаар шалгана
3. Ерөндөгийг авна, 10 өдөр Доксациклин уулгана
4. Байранд нь үлдээнэ, жирэмсний хяналтыг үргэлжлүүлнэ
5. Жирэмсэн үед ерөндөгтэй байх нь авах заалт биш

## 47 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

Кесар мэс заслаар төрсний дараа шээс гарахгүй байхад аль нь эрсдэлт хүчин зүйл болох вэ?
1. Цус алдалт
2. Хэсгийн мэдээгүйжүүлэг
3. Өмнө нь кесар мэс заслаар төрсөн
4. Мэс заслын дараах наркотик мэдээгүйжүүлэг
5. Шингэний дутагдал

## 48 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Хорин нэгэн настай анхан төрөгч, 41 долоо хоногтой, ураг орчмын шингэн бага тул төрөлт сэдээсэн. Төрлөгийн 2-р үед 3 цаг дүлсэн боловч ургийн толгой 0-ээс доошлохгүйгээс кесар мэс заслаар төрүүлсэн. Ургийн толгойг үтрээгээр дээш түлхэж, төвөгтэй гаргасан. Нярайн толгойд (рентген зурагт үзүүлсэн) дарагдлын хугарал үүссэн. Кесар мэс заслын ойролцоогоор хэдэн хувь нь ургийн гэмтлээр хүндэрдэг вэ?

1. 0.1%
2. 0.5%
3. 1.0%
4. 1,5%
5. 2,0%

**49** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Гучин дөрвөн настай, анхны жирэмсэн, жирэмсний хяналтын үзлэгтээ ирэхэд 12 долоо хоногтой гэж тодорхойлов. Эмэгтэй төмрийн бэлдмэл агуулсан витамин ууж байснаа зогсоосон байна. Түүний цусыг шинжлэхэд гемтокрит 39% байна. Цаашид энэ эмэгтэйд төмрийн бэлдмэлийг зөвлөх үү?

1. Цус багадалтгүй тул төмрийн бэлдмэл уух шаардлагагүй
2. Төмрөөр баялаг хүнсний хэрэглээ хэвийн байгаа тул төмрийн бэлдмэл уух шаардлагагүй
3. Төмрийн бэлдмэл нэмэлтээр уухгүй бол ураг нь цус багадалтанд өртөнө
4. Жирэмсний хугацаанд төмрийн хэрэгцээгээ нөхөхийн тулд цус багадалт үүсээгүй ч төмрийн бэлдмэлийг уух шаардлагатай
5. Хэрэв гематокрит 36%-аас багасвал төмрийн бэлдмэл ууж эхлэх

## 50 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

28 настай анхны жирэмсэн, одоо 24 долоо хоногтой хяналтанд ирж үзүүлэхээр ирсэн. Түүний гол зовиур нь баруун талын цавь орчимд ялангуяа алхах, дасгал хийхэд өвдөх ба өвдөлт энэ үед нэмэгдэнэ. Халуураагүй, чичрүүдэс байхгүй. Шээсэнд өөрчлөлтгүй, хэвлийн бусад хэсгээр өвдөлтгүй, өтгөн хэвийн гарна. Өвдөж буй газарт бүлээн жин тавихад өвдөлт багасна. Өвдөлтийн шалтгаан дараах жагсаалтаас аль нь хамгийн зөв байх магадлалтай вэ?

1. Дугуй холбоосны өвдөлт
2. Мухар олгойн үрэвсэл
3. Дутуу төрөлт
4. Бөөрний чулуу
5. Шээсний өгөх замын халдвар

**51** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

33 настай анхны жирэмсэн, 10 долоо хоногтой хяналтын үзлэгт ирсэн. Шинжилгээнүүд хийгдсэн ба элэгний В вирусын гадаргуугийн антиген эерэг хариу гарсан. Элэгний үйл ажиллагаа хэвийн. Гепатитын В вирусын цөм антиген, гадаргуугийн антител сөрөг хариутай гарчээ. Нярайд халдвар дамжихаас сэргийлэхийн тулд ямар зөвлөмж өгөх вэ?

1. Эхэд иммуноглобулин тарих
2. Эхэд гепатитын В вирусын вакцин тарих
3. Төрөх хугацаа болохоор кесар хагалгаагаар төрөх Нярайд гепатитын В вирусын эсрэг вакцин тарих
4. Нярайд гепатитын В вирусын эсрэг вакцин болон иммунноглобулин тарих

**52** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Төрөлтийн 1-р үеийн идэвхитэй шатанд эпидураль мэдээгүйжүүлэг хийлгэхэд урагт зүрхний цохилтонд удааширсан удаашрал үүссэн бол үндсэн шалтгааныг тайлбарлана уу

1. Хүй унжих
2. Эпидурал мэдээгүйжүүлэг
3. Окситоцины эрчимжүүлэлтээс үүдэлтэй Ихсийн ховхрол
4. Умайн хэт цочрол/гиперстимуляци

**53 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

36 настай эмэгтэй, жирэмслэлт 1, төрөлт 1. Төрсний дараах үзлэгтээ хамрагдахаар ирсэн. Одоогоос 6 долоо хоногийн өмнө төрөх замаар төрсөн. ЖСА -ийн арга сонгон хэрэглэх хүсэлтэй бөгөөд ямар нэгэн хавсарсан эмгэг байхгүй. Тамхи татдаггүй, ямар нэгэн эм байхгүй. Эмэгтэйд зөвлөгөөг өгөхдөө дараах аргуудын аль хөхний сүү үүсэлтийг бууруулдаг гэж тайлбарлах вэ?

A. Умайн ерөндөг
B. Зөвхөн прогестрон агуулсан шахмал
C. Депомедроксинпрогестрон ацетат
D. Хавсарсан даврын бэлдмэл
E. Бэлгэвч, спермецидын хөөс

## 54 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

71 настай эмэгтэй, жирэмслэлт 2, төрөлт 2, урьдчилан сэргийлэх үзлэгт орохоор ирсэн. Сүүлийн 10 жилд эмчид үзүүлээгүй, Пап тест өчигдөр өгөөд хэвийн гарсан, ямар нэгэн эм хэрэглэдэггүй. 1 удаа гэрлэсэн, тамхи татдаггүй, архи спиртыг маш ховор хэрэглэдэг, АД 140|70 мм муб. Жин 76 кг, өндөр 160 см. Дараах урьдчилан сэргийлэх шинжилгээнүүдээс алийг нь зөвлөх вэ?

1. Пап тест, маммограм
2. Пап тест, маммограм, бүдүүн гэдэсний дуран
3. Маммограм, бүдүүн гэдэсний дуран, ясны сийрэгжилтийн шинжилгээ
4. Маммограм, бүдүүн гэдэсний дуран, ясны сийрэгжилтийн шинжилгээ, туберкулины тест
5. Маммограм, бүдүүн гэдэсний дуран, ясны сийрэгжилтийн шинжилгээ, туберкулины сорил, сонсголын шинжилгээ

**55** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

45 настай эмэгтэй жирэмслэлт 1, төрөлт 1, хөхний карцинома оношлогдсон. Дараах зүйлээс аль нь хавдрын эмчилгээний прогнозод хамгийн чухал байдаг вэ?

1. Оношлогдсон нас
2. Хавдрын хэмжээ
3. Суганы булчирхайд үсэрхийлсэн эсэх
4. Эстрогений рецептортэй эсийн хадвар
5. Прогестрон рецептортой эсийн хавдар

**56** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Дараахаас ахондроплази өвчний онцлогийг аль нь илтгэж байна вэ?

1. Аутосомийн рецессив байдлаар удамшдаг
2. Нийт тохиолдлуудаас 50%-ийн шинэ мутаци эзэлдэг
3. Кесар хагалгаа цөөхөн тохиолддог
4. Өвчтэй бол нөхөн үржихүйн нас хүртлээ амьдрах нь ховор
5. Нурууны гажиг нь хүйн дарагдалд нөлөөлдөг

**57** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Аорт аль нугаламын түвшинд ташааны ерөнхий 2 артери болж салаалдаг вэ?

1. Сээрний 12-р нугаламын түвшинд
2. Бүсэлхийн 2-р нугаламын түвшинд
3. Бүсэлхийн 4-р нугаламын түвшинд
4. Ууцны 1-р нугаламын түвшинд

**58** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Бернерийн хавдар өндгөвчийн хавдрын ямар ангилалд хамаарах вэ?

1. Үр хөврөлийн гаралтай
2. Бэлгийн татлагын
3. Тулгуурын
4. Хучуурын гаралтай
5. Даавар хамааралтай

**59** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Нөхөн Үржихүйн технологийн аль нь ургийн гаж хөгжил үүсгэх эрсдэл илүү вэ?

1. Хөлдөөсөн үр хөврөл шилжүүлэн суулгах
2. Өндгөвчийг хориальный гонадотропин релизинг дааврын аганистоор сэдээсэн
3. Өндгөвчийг хориальныы гонадотропин релизинг дааврын антогонистоор сэдээсэн
4. Хуруу шилэнд үр тогтоосон
5. Цитоплазмд эр бэлгийн эс тарьсан

**60** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Марсупиализаци мэс ажилбарын зорилго нь юу вэ?
1. Хурсан шингэн, идээрийг гаргах
2. Бартолин булчирхайд цорго шинээр үүсгэх
3. Бартолин булчирхайг авах
4. Бартолин булчирхайг үлдээх
5. Бартолин булчирхайг буглааны гэрийн хамт авах

**61** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Ургийн халдварын тархалтын үнэн зөв мэдээллийг нэрлэнэ үү
1. ХДХВ -ийн халдвар эхээс урагт дамжих эрсдэл 15-20%
2. Парвовирусын халдвар жирэмсэн үед ойролцоогоор 3% тохиолдох ба урагт цус багадлт үүсгэнэ
3. В вирусийн гепатитийн урьдчилан сэргийлэлт хийхгүй бол урагт халдвар дамжих эрсдэл 50%
4. Цус задлагч стрептококк нь урагт хүнд хэлбэрийн халдвар үүсгэнэ
5. Токсоплазмын халдвар жирэмсний 3 дах 3 сард урагт халдвар дамжих эрсдэл 15%

## 62 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

Биений юмны өмнөх хам шинжийн үед аль эмчичлгээний аргыг сонгох вэ?
1. Тайвшруулах эмчилгээ
2. Жирэмснээс хамгаалах хавсарсан даврын бэлдмэл
3. Витамин B6
4. Флуоксатин (SSRI)
5. Давс хязгаарлах

1. 1, 2, 3 дугаар хариултууд зөв
2. 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв
3. 2 ба 4 дугаар хариултууд зөв
4. Зөвхөн 4-р хариулт зөв
5. Бүх хариулт зөв

## 63 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

Прогестин хэрэглэхэд ургийн ямар гаж хөгжил үүсэх эрсдэлтэй вэ?

1. Хондрадисплази
2. Мэдрэлийн тогтолцооны гажиг
3. Хуруугүй төрөх
4. Гипоспади Сэтэрхий уруул

**64** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Цусанд Альфафетопротеин багасах нь урагт ямар эмгэг байгааг илтгэх вэ?

1. Омфалоцеле
2. Ананцефали
3. Ихэс ховхролт
4. Трисоми
5. Ураг амьгүй болох эрсдэлтэй

**65** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Эндометриозын эмчилгээ 2 сар хийлгэсэн, нүүр халуу оргиж, үтрээ хуурайших, шинж илэрсэн. Дараах эмүүдийн аль нь ийм байдал үүсгэх вэ?

1. Андрогены бэлдмэл
2. Гонадотропины релизинг даавры агонист
3. Жирэмслэхээс хамгаалах даавры хавсарсан бэлдмэл
4. Прогестаген
5. Стеройд бус үрэвслийн эм

**66** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Даавар орлуулах эмчилгээ хийж болох тохиолдлыг нэрлэнэ үү?

1. АД ихсэлт
2. Альцгеймерийн эмгэг
3. Элэгний хурц үрэвсэл
4. Гэр бүлийн гиперлипидеми
5. Хөхний хавдрын улмаас хөхөө авхуулсан

**67** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

БЮМ –ийн 24 дэх хоногт умайн хүзүүний салиа 10-12 см сунах нь юуг илтгэх вэ?

1. Өндгөн эс гадагшлалтгүй мөчлөг
2. Гиперандрогени
3. БЮМ –ын 2 шат богиноссон
4. БЮМ –ийн 1 шат богиноссон
5. Хэвийн БЮМ байгааг

**68** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Ургийн хромосомын эмгэгийн оношилгоонд алийг өргөн ашигладаг вэ
1. Хоёрол тест
2. Цэлмэнгийн биопси
3. Ургийн шилний арын зайн зузаан хэмжилт (NT)
4. Амниоцентез
5. Гурвал тест

1. 1, 2, 3 дугаар хариултууд зөв
2. 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв
3. 2 ба 4 дугаар хариултууд зөв
4. Зөвхөн 4-р хариулт зөв
5. Бүх хариулт зөв

**69** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Гонадотропины ялгаралтыг идэвхижүүлэх бэлдмэл?

1. Летрозол
2. Синестрол
3. Этинилэстрадиол
4. Тамоксифен
5. Клостильбегит

**70** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Киари- Фромеллийн хамшинжийн үед илрэх эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?

1. Умай жижигрэх
2. Биений юмгүйдэл
3. Пролактин ихсэх
4. Үсжих
5. Өндгөвч томрох

**71 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Хэт авиан шинжилгээнд ихэс зузаан бол ямар эмгэгийг сэжиглэх вэ?

1. Тамхи таталт
2. Чихрийн шижин
3. Гаж хөгжил
4. Тэмбүү
5. ХДХВ-ийн халдвар

**72 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Жирэмсний эхний 3 сартайд ургийн NT зузаарал юутай хамааралгүй вэ

1. Дауны хамшинж
2. Ургийн өсөлт саарах хамшинж
3. Птаугийн хамшинж
4. Манас таталтын урьдал
5. Эдвардсын хамшинж

## 73 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)

"Эмнэлгийн мэргэжилтэн" тодорхойлолтыг сонгоно уу

1. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг
2. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, уламжлалтын их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг
3. Хүний их, бага эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг
4. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг
5. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн эмнэлгийн бусад ажилтныг

**72** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Хучуурын гаралтай хавдрын хяналтанд аль маркеруудыг ашиглах вэ?

1. HE4
2. CA125
3. CEA
4. CA 19.9
5. AFP

**75** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Яаралтай жирэмслэхээс сэргийлэх аргуудыг нэрлэнэ үү?

1. Левоноргестрол
2. ДХЭ
3. Зэс агуулсан ерөндөг
4. Улипристал ацетат
5. Үтрээ угаах

**76** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Хэт авиан Допплер шинжилгээний индексүүдийг нэрлэнэ үү
1. Агшилтын дээд хурд
2. Эсэргүүцлийн индекс
3. Тархи ихсийн харьцаа
4. Лугшилтын индекс
5. Сулралын муруй

**77** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Том жинтэй хүүхэд төрүүлж байсан, жирэмсэн эмэгтэйд глюкозын ачааалалтай сорилоор өлөн үеийн сахар 5.4 ммоль/л, 1 цагийн дараа 12.5 ммоль/л, 2 цагийн дараа 8.4 ммоль/л бол юу гэж тайлбарлах вэ?

1. Хэвийн
2. Чихрийн шижин илэрсэн
3. Сорил өөрчлөлттэй
4. Сорилыг давтан хийх
5. Сорилыг инсулин 7 хоног хэрэглсэний дараа давтан хийх

**78** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Төрсний дараа мэдрэл саажилт үүсэх шалтгаан, илрэх шинжийн зөвийг нэрлэнэ үү

1. Төрөлтийн үед удаан хугацаагаар өвдөг нугалаатай байх
2. Шилбэний нарийн ясны толгойд даралт учирсанаас
3. Дүлэх үед гарын алганд даралт учирсанаас
4. Мак Робертсийн байрлалын үед
5. Хэвлий дээр дарах үед

**79** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Гүний венийн тромбозыг илрүүлэхийн тулд цуврал даралтат хэт авиан шинжилгээг хэд дэх өдрүүдэд үзэх хэрэгтэй вэ?

1. Өдөр бүх хянаж үзнэ
2. 2, 4 дэх өдөр
3. 3, 7 дах өдөр
4. 4, 8 дах хоног
5. 10 хоногт 1 удаа

**80** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Аденокарцинома үүсэх шалтгааныг нэрлэнэ үү

1. Эстрогений илүүдэл
2. Таргалалт
3. Чихрийн шижин
4. Артерийн даралт ихдэх өвчин
5. Өндгөвч уйланхайжих хамшинж

**81** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Харааны товгороос дараах даавруд ялгарна:

1. Рилизинг- даавар
2. Станины даавар
3. Вазопресин
4. Окситоцин
5. Мелатонин

**82 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Дараах эмүүдээс аль нь жирэмсний 2-р хагасаас хойш УОШ-ийг багасгах үйлчилгээ үзүүлэх вэ?
1. Гидролазин
2. Ветаблокатор
3. Кальцийн сувгийг саатуулагч
4. Ангиотензин сувгийн саатуулагч
5. Карбомезапин

**83 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Аденомиозыг тархалтын ангиллын II зэрэгт хамаарахыг сонгоно уу?

1. Умайн их биеийн зөвхөн салстад эмгэг өөрчлөлт байрших
2. Умайн булчинт давхаргын 1/3-ийг хамарсан байх
3. Умайн булчинт давхаргын талыг хамарсан байх
4. Эмгэг процесс умайн бүх ханыг хамарсан байх
5. Эмгэг процесс умайн хананаас хальж, хэвлийн гялтан, зэргэлдээх эрхтэнд үүссэн байх

**84** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Э.., 24 настай, жирэмсний 17 долоо хоногтой. Цусны сийвэнд АФП-ны түвшин 6.0 МОМ бол дараагийн шатанд эхлээд авах авах арга хэмжээг нэрлэнэ үү?

1. АФП-ыг давтан хэмжих
2. Хэт авиан шинжилгээ
3. Амниоцентез
4. Амниографи
5. Жирэмснийг таслахыг зөвлөнө

**85** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Жирэмсний төгсгөлд үтрээний цитологи шинжилгээнд ямар эс давамгайлах вэ?

1. Гадаргуугийн эс
2. Завсрын эс
3. Суурь эс
4. Суурийн хажуугийн эс
5. Суурь ба суурийн хажуугийн эс

**86 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Хэвлийн урд хананы өнгөц судасжилтанд аль судас оролцох вэ?

1. epigastrica superior
2. Superficial circumflex artery
3. epigastrica inferior
4. illiaca circumflex

**87 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Умайн ёроолын тунгалагийн урсгал нь аль зангилаанд цутгах вэ?

1. Ташааны гадна зангилаанд
2. Ташааны дотор тунгалагийн зангилаанд
3. Цавины өнгөц тунгалагийн зангилаанд
4. Гол судасны зангилаанд
5. Давсаг орчмын зангилаанд

**88** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Аль нь илүү тээлт үүсгэхэд хамааралтай вэ?

1. Менингомиелоцеле
2. Нугасны эвэрхий
3. Тархигүй ураг
4. Омфалоцеле
5. Тернерийн хам шинж

**89** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Өмнө нь дутуу төрж байсан эмэгтэйд, дахин дутуу төрөхөөс сэргийлж дараах эмчилгээнээс алийг нь хийх вэ?

1. Жирэмсний 32 долоо хоног хүртэл токолитик бага тунгаар хэрэглэнэ.
2. Дутуу төрөхийг завдаж байгаа үед Магне B6 жирэмсний туршид хэрэглэнэ.
3. Зовуургүй бол хяналт тавьж ажиглана.
4. Жирэмсний 37 долоо хоногоос өмнө 17α гидроксипрогестерон 250 мг – аар, булчинд, 7 хоног тутамд тарина.
5. Умай тонустай үед, 17 α гидроксипрогестерон өдөрт 1 удаа, 7 хоног хэрэглэнэ.

**90** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Өндгөвчийн эрт цуцах (эрт дутагдах) хамшинж үүсэхэд хүргэх шалтгаан нь:

1. Удамшлын шалтгаан
2. Нөхөн үржихүйн насанд фолликулын сөнөрөл хэт идэвхитэй явагдах
3. Туяаны үйлчлэл
4. Улаануудын халдвар
5. Х хромосомын дутагдал

**91 Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

В вирусын гепатиттай холбоотой зөв мэдээллийг нэрлэнэ үү?
1. Босоо замаар халдвар дамжих эрсдэл ихсээр дамжихаас бага
2. HbeAg эсрэг төрөгч илрэх нь халдварын далд үе шатыг илэрхийлнэ
3. В вирусын гепатит жирэмсний эхний 3 сард үүсвэл ургийн гаж хөгжил үүсгэнэ
4. Вирусын ачаалал өндөр бол 28 долоо хоногтойгоос вирусын эсрэг эм хэрэглэнэ
5. Халдвартай эхээс төрсөн нярайд 12 сарын дараа шинжилгээ хийнэ.

**90** **Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)**

Жирэмсэн үед гепатит С-тэй хамааралтай зөв мэдээллийг нэрлэнэ үү?

1. HIV-тай хавсрах нь эхээс урагт халдах эрсдэл нэмэгдэнэ.
2. Жирэмсэн үед интерферон хэрэглэх нь эсрэг заалттай
3. Жирэмсэн үед С гепатитын хурц хэлбэр ховор тохиолдоно.
4. Эхээс урагт халдах эрсдэл 3-5%
5. Вирусын ачаалал >2.5x$10^6$ copies/ml DNA бол өндөр гэж үзнэ

**93** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Креатинин хэд байх нь үжлийг үнэлэх SOFA үнэлгээгээр 3 оноо өгөх вэ?

1) <1.2 -1.9 мг/дл
2) 2.0-3.4 мг/дл
3) 3.5-4.9 мг/ дл
4) 5.0-5.5 мг/дл
5) >6.0 мг /дл

**94 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Жирэмсний 32 долоо хоногтой. Хэт авиан шинжилгээнд УОШ-ний ээлэхүүн 32 см бол дараахаас аль нь байж болох вэ?

1. Ургийн 12 нугалаа гэдэсний битүүрэл
2. Ургийн бөөрний эмгэг
3. Резус мэдрэгшил үүссэн
4. HELLP хамшинж
5. Тромбоцитопенийн пурпура

**95 Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Анти D эсрэгбие үүсээгүй бол иммуноглобулинг урьдчилан сэргийлэх ямар тунгаар хэрэглэх вэ?

a. 150
b. 200
c. 250
d. 300
e. 350

Үйл ажиллагааны ямар сорилууд эстроген дааврын ханалтыг тодруулдаг вэ?

1. Хүүхэн харааны шинж
2. Кариопикнетик индекс
3. Оймын навчны шинж
4. Суурин халууны шинж
5. Кольпоцитологи

Умайн хүзүүний цагаарал нь:
1. Ихэвчлэн 30-35 насны эмэгтэйчүүдэд тохиолдоно
2. Олон үет хучуурын эсүүд эвэршин зузаарах
3. Гадаргуугийн үенүүд нь нимгэрч суурин эсүүд зузаарна
4. Доод талын эдүүдтэйгээ нягт наалдана
5. Богино хугацаанд өмөнд шилжинэ

Ёс зүйн хүрээнд эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчдэд ямар ямар тохиолдолд шууд нөлөө үзүүлэх ёсгүй бэ?

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад нь
2. Харьяалал харгалзахгүй үйлчлүүлэхэд нь
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах байгууллага, эмчээ сонгоход эрхээ эдлэхэд нь
4. Эмийн сангаар үйлчүүлэхэд нь
5. Шилжин суурьшихад нь

Элгэн доторхи цөс зогсонгшил нь ямар хүндрэл үүсгэх вэ?
1. Гэдэс зунгагаар түгжрэх
2. Ураг амьгүй болох
3. Дутуу төрөх
4. Ургийн халдвар
5. Ургийн өсөлтийн саатал

**100** **Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх)**

Эмэгтэй Н.., 32 настай, 3 дах төрөлт, жирэмсний 32 долоо хоногтой. Ургийн жин байх ёстой хэмжээнээс бага, эмэгтэй өдөрт нэг хайрцаг тамхи татдаг. Дараах шинжилгээний алийг нь хийх шаардлагатай вэ?

1) Эстриол
2) Прогестерон
3) Пролактин
4) Андроген
5) ХГ

1. Жирэмслэхээс өмнө фолийн хүчил уусанаар урагт мэдрэлийн гуурсны гаж хөгжил үүсэх эрсдэлийг хэдэн хувь бууруулах вэ?
   A. 11%
   B. 26%
   C. 50%
   D. 72%
   E. 90%
2. Дэлхийд хамгийн түгээмэл тохиолдох нэг генийн эмгэгт аль нь хамаарах вэ?
   A. Гемоглобинопати
   B. Гликоген нөөцлөгдөх өвчин
   C. Фенилкетонури мутаци
   D. Уйланхайт фиброз
   E. Дюшены булчингийн дистрофи
3. Жирэмсний аль хугацаанаас агаарын тээврээр зорчихыг зөвлөдөггүй вэ?
   A. 26 долоо хоног
   B. 28 долоо хоног
   C. 30 долоо хоног
   D. 32 долоо хоног
   E. 36 долоо хоног

4. Жирэмсэн үед Кортикотропийн сэдээгч дааврын анхдагч эх үүсвэр аль нь болохыг нэрлэнэ үү

A. Ихэс
B. Ургийн бөөрний дээд булчирхай
C. Ургийн харааны товгор
D. Эхийн харааны товгор
E. Хорион бүрхүүл

5. Дауны хамшинжийг илрүүлэхэд жирэмсний 19-24 долоо хоногтойд ургийн дагзны арьсны зузаан(NF)-ы босго хэмжээ зурагт харуулсан цагаан тэмдэгтээр хэд бол ээрэг гэж үзэх вэ?




A. ≥6 мм
B. ≥7 мм
C. ≥8 мм
D. ≥9 мм
E. ≥10 мм

6. Mirror буюу толин тусгал хамшинжид дараахаас аль нь хамаарах вэ?
   1. Эхийн хаван
   2. Артерийн даралт ихсэлт
   3. Шээсээр уураг алдах
   4. Ургийн гидропс
   5. Элэгний трансаминаз ихсэх
7. Ургийн тахиаритми гэдэг нь ургийн зүрхний цохилт 1 минутанд 180-200 удаа болохыг хэлнэ. Ямар шалтгаанаас үүсэх вэ?
   1. Бамбайн дутагдал
   2. Ургийн халдвар
   3. Манас таталтын урьдлын хүнд хэлбэр
   4. Ургийн цус багадалт
   5. 28 долоо хоног хүртэл урагт илэрч болно
8. Ургийн уушгины хөгжлийг үнэлэх аргуудыг нэрлэнэ үү
   1. Ургийн шингэнд лецитин-сфингомиелины харьцаагаар
   2. Ламел биетийг тоолох
   3. Фосфатидилглицерин (PG)
   4. Хэт авиан оношилгоо
   5. Фибронектин
9. Дутуу төрөлтийн үед умайн булчингийн агшилтыг зогсоох зорилгоор хэрэглэх Нифидепины цохилтын тунг нэрлэнэ үү?
   A. 10 мг-аар 20 хормын зайтай 3 удаа
   B. 20 мг-аар 20 хормын зайтай 3 удаа
   C. 30 мг-аар 20 хормын зайтай 3 удаа*
   D. 30 мг-аар 1 удаа
   E. 10 мг-аар 10 мин зайтай 3 удаа
10. Ураг орчмын шингэн цагаас өмнө гарсан үед хүлээх төлөвлөгөөтэй бол ямар арга хэмжээ авах вэ?
    1. Үтрээний үзлэгийг 12 цагийн зайтай хийнэ

2. Биеийн халууныг 4 цагийн зайтай үзнэ
3. Цусанд цагаан эсийг 12 цаг тутамд үзнэ
4. Цусанд С уургийг өдөр бүр үзнэ
5. 37 долоо хоног хүрээгүй бол токолитик хэрэглэнэ

11. Донорын цусанд ямар халдварыг заавал илрүүлэх вэ?
    1. ХДХВ
    2. Тэмбүү
    3. В гепатит
    4. С гепатит
    5. Цитомегаловирус
12. Цус буруу сэлбэснээс үүдэлтэй анафилаксийн дайрлагын үед хийх эмчилгээнээс хамааралтайг нэрлэнэ үү
    1. Адреналин
    2. Прометазин
    3. Гидрокортизон
    4. Амминофиллин
    5. Аналгин
13. Лидокайныг хэсгийн мэдээ алдуулалтанд 40 мл-ээс их хэмжээтэй хэрэглэхээр бол адреналиныг ямар тунгаар нэмж өгөх вэ?
    A. 2 мкг/кг
    B. 5 мкг/кг
    C. 6 мкг/кг
    D. 8 мкг/кг
    E. 10 мкг/кг
14. Цулцан хураа оношоор умайн хөндийг цэвэрлүүлсэн эмэгтэйд ямар хугацаанд ХГ хэвийн байдалд хүрэхгүй бол хориокарциномын удирдамжийн дагуу хавдар судлалын төвд шилжүүлэх вэ?
    A. 4 долоо хоног
    B. 6 долоо хоног
    C. 8 долоо хоног
    D. 10 долоо хоног
    E. 12 долоо хоног
15. BRCA 1 нь өндгөвчний өмөн үүсэх эрсдэлийг хэдэн хувь нэмэгдүүлэх вэ?
    A. 15%
    B. 20%
    C. 30%
    D. 40%
    E. 50%
16. Ургийн биофизик үзүүлэлтээр ургийн амьсгалын хөдөлгөөн 30 секундэд хэдэн удаа илэрвэл 2 оноо өгөх вэ?
    A. 0
    B. 1
    C. 2
    D. 3
    E. 4
17. Төрсний дараа дунд чөмөгний мэдрэл дарагдлын шинжтэй хамааралтай зөв мэдээллийг нэрлэнэ үү?
    1. Удаан хугацаагаар өвдөг нугалаатай байх
    2. Мак Робертсийн байрлалд удаан байлгах
    3. Дүлэлтийн үед шилбэний нарийн ясанд даралт учирснаас
    4. Гуяны урд дотор талын мэдрэхүй алдагдах шинж илэрнэ
    5. Хүндээр бие засах мэдрэмж өөрчлөгдөх

18. Макроцитарны цус багадалтанд аль нь хамаарах вэ?
    1. Остеомиелит г.м халдвар
    2. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
    3. Хар тугалганы хордлого
    4. Эмийн хамааралтай
